

Монгол хүмүүний үндэсний язгуур үзэл

Содовсүрэнгийн Нарангэрэл

ШУА-ийн академич, ШУ-ны доктор, профессор, narangerel@iss.gov.mn
Монгол Улсын Их Сургуулийн Эмерит профессор

Хураангуй

Энэхүү өгүүлэлд XIII зууны үед монгол үндэстэн дэлхийн хамгийн ёс суртахуунлаг хүчирхэг үндэстэн байсны учрыг тайлж, яваандаа энэ үндэстэн яагаад сулран доройтож, харийн хараат байдалд хүртэл орж, дараа нь үндэсний тусгаар тогтнолоо олж авч чадсан ч эдүгээ дээрдэхгүй байгаагийн шалтгааныг тайлбарлахыг хичээсэн болно.

Их эзэн Чингис хааны гал голомтыг сахин хамгаалан буй өнөөгийн Монгол Улс, Монголын ард түмний ёс суртахууны уламжлалт чиг баримжаа нэлээд алдуурсан байна. Ингэсний үр дүнд түүх, соёлын арвин баялаг өвтэй, өргөн уудам нутаг дэвсгэртэй, дэлхийд цорын ганцхан үлдсэн малын бэлчээр дагасан нүүдлийн соёл иргэнишлтэй, ард түмэн нь авьяас билэгтэй, байгалийн нөөц баялаг ихтэй манай улс өөрт ашиггүйгээр бусдын аяст автагдахаас өөр аргагүй байдалд хүрчээ. Ийм нөхцөл байдалд манай улс зөвхөн агишин зуурын асуудалдаа анхаарал хандуулж ирэв. Тийм учраас энэхүү өгүүлэлд монголчууд ёс суртахууныхаа эрхэм нандин ой санамжаа сэргээх нь ямар чухал ач холбогдолтой болохыг товч өгүүлэхийг хичээнгүйлэн эрмэлзсэн болно.

Түлхүүр үгс: Тусгаар тогтнол; ёс суртахууны үнэт зүйл; эв нэгдэл; итгэл үнэмшил; нүүдлийн соёл иргэнишл; нийгмийн үнэт зүйлс

Монголчууд XIII зуунд хүчирхэг ард түмэн байсны эх үүсвэр

Манай эриний өмнөх Хүннү гүрний үеэс Алтайгаас Их Хянганы уулсын хооронд аж төрж, үндсэн амин зуулгаа бэлчээр, ундны цэвэр ус дагасан мал сүрэг болгож, түүнээс улбаалсан ёс заншил, соёл бүхий улс түмний үр сад болох Хиад овогтон тэргүүлсэн эртний монгол дөрвөн овгийнхон Бөртэ чоно (Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоон., 2024. , хууд. 37)¹ ба Гоо марал² нарыг дагаж нүүдэллэсээр Бурхан халдун орчимд буурин дээрээ манай эриний VIII зууны II хагас IX зууны эхээр буцаж ирцгээж, гал голомтоо дахин бадраажээ. Тэд энэ нутгаас илүү сайхан газар орон огт үгүй болохыг сайтар ухаарсан бөгөөд ийнхүү язгуурын монголчуудын гол цөм энд бүрджээ. Язгуурын монголчууд ийнхүү Онон, Хэрлэн, Туул хэмээх гурван гол мөрний сав газарт төвлөрөн нутагшиж, дэлхий дахинд зард

¹ Түүхийн эх сурвалжид Чингис хааны хамгийн дээд өвгийг Бөртэ чоно эрхэмбээр хэмээн бичиж үлдээсэн бөгөөд 758 онд төрсөн гэж үздэг.

² Чингис хааны дээд өвөг Бөртэ чоно эрхэмбээрийн гэргий.

гарсан мартагдашгүй үүх түүх нь чухамхүү эндээс эхэлжээ. Монголчууд гурван мөрний хөндийд багтахын аргагүйгээр олшрох үед мал сүргээ идээшлүүлэн дөрвөн зүг найман зовхис тийшээгээ тарж нүүцгээв.

Монгол үндэстний оюун санааны уг сурвалж нь ёс суртахуунд нь оршиж байв. Ёс суртахуун хүмүүний хувьд үүсмэл (итгэл үнэмшил, зарчим) бус харин байгалиас заяагдмал болохыг агуу Аристотелиос (Аристотель, 2015, хууд. 48)³ эхлээд суут сэтгэгчид олж тогтоож, орчин үеийн байгалийн шинжлэх ухаан тухайлбал, квантын физик, энергийн таталцлын хууль, эсийн биологи (ДНХ), биофотон судлалын ололтоор нотлогдсоор байгаа билээ. Тухайлбал: ёс суртахууны физик (fiscal moral) нь сансрын доторх хүмүүн ухаж ойлгосон болон сайн дурын үндсэн дээр оюун ухаанаараа ухамсраа дээд түвшинд хөгжүүлэх замаар туйлын өндөр амжилт ба аз жаргалд хүрэх чадвартай гэсэн гаргалгааг буй болгожээ.

Монгол үндэстэн хүмүүний хоорондын хүйтэн цэвдэг, бүдүүлэг харьцааг эелдэг найрсаг, зочломтгой; шударга бус үйлийг нь чигч шударга; аймхай, хулчгар занг эрэмгий зориг, дайчин чанар; хазааргүй шунал, хэрэглээг эс шунахуй; эрээ цээргүй, ичгүүр сонжуургүй ааш авирыг ичих ба эмээх мэдрэмж; цалгар назгай, хариуцлагагүй явдлыг үүргээ биелүүлж, хариуцлагаа ухамсарлах; хүний мөсгүй, хүнлэг бус чанарыг жудаг; харгис хэрцгий, балмад үйлийг нинжин сэтгэл; хууран мэхлэх, итгэл эвдэх, хулхидах явдлыг итгэл даах; нэр нүүрээ барах явдлыг нэр төрөө эрхэмлэх; хагарал, талцал, үзэн ядалт, дайсагналцлыг эв нэгдэл; урван тэрслэлтийг үнэнч зан; атаархал, хорсол, атгаг сэтгэл, өс хонзон, хорон муу санаархлыг нигүүсгэл болгон өөрчилж чаджээ.

Түүнчлэн хөвгүүн нь эцгийнхээ сургаалыг хүлээн авдаг, дүү нь ахынхаа үгийг дагадаг, эр нь гэргийдээ итгэдэг, гэргий нь эрийнхээ үгэнд ордог, хадам нь бэрээ хайрладаг, бэр нь хадмаа халамжилдаг, том нь багаа хүмүүжүүлдэг, бага нь томдоо захирагддаг болгосон байна. (Рашидадин, 2013, хууд. 448-449) Энэ дэлхийн хамгийн өндөр ёс суртахуунлаг монгол үндэстний төр улс нь Хамаг Монгол Улс болж байв. Энэ улсын нутаг дэвсгэр нь зүүн зүгт Хянганы нуруу (эдүгээгийн БНХАУ-ын нутаг дэвсгэрт оршиж буй), баруун зүгт Байгаль далайн цаадах Эрчис мөрөн (эдүгээгийн ОХУ-ын Сибирийн нутгаар урсаж буй Обь мөрний цутгал мөрөн), өмнө зүгт Хятадын их цагаан хэрэм, хойд зүгт умард Сибирь, тундрт оршиж байжээ. Тал голдуу ийм уудам нутаг дэвсгэртэй, жилийн дөрвөн улиралтай, үндсэн амин зуулга нь мал сүрэг болсон ард түмэнд бусдын газар нутагт шунах ямар ч шаардлага байсангүй.

ХIII зууны үед Монгол Улсын нийт хүн ам нэг сая хүрэхээргүй, насанд хүрээгүй эрэгтэй хүүхдээ цэрэгт татахад дайчид нь нэг зуун мянгад тоологдохгүй, нум сум, жад, агт морьдоос өөр зэр зэвсэг гэхээр зүйлгүй байжээ. Тэгвэл яагаад энэ зуунд монголчууд дэлхийн өнцөг булан бүрт очив гэвэл монголчуудын ёс суртахууны эерэг энергид дэлхий дахин татагдаж, дэлхийн хаана шударга ёс, энхийг тогтоох гарцаагүй шаардлага үүдэгдэнэ, тэнд монголчууд дуудагдаж хүрэлцэн очих болжээ.

³ Суут сэтгэгч Аристотель одоогоос 2500 жилийн өмнө ёс суртахуун нь “аль ч хүнд зайлшгүй байхаар заяагдсан, тэгэхдээ адил ижлээр бус” гэж бичжээ.

Яагаад дэлхийн тал гэсээр байтал дэлхий дахинд гэж бичих болов гэвэл XIII зуунд даян дэлхий зөвхөн Европ, Ази тивээр төсөөлөгдөж байжээ. Африк тивийн баруун эргийг л XV зуунаас португальчууд анх нээжээ. Европтой харьцуулахад дорно, өрнийг холбосон Монголын эрин үе нэгэнт улиран одсон боловч Өрнийнхөн - Европчууд Марко Поло⁴-гийн аян замын тэмдэглэлийг бие биеэсээ өрсөн уншицгаажээ. Эл аян замын тэмдэглэл (Лэйтхэм, 2012) бүхэлдээ шинэ газар, шинэ нэрс, шинэ бараа таваар, баялаг, шинэ адал явдал, шинэ нээлтүүдэд уриалсан нэг ёсны дуудлага болов. Марко Пологийн аян замын тэмдэглэлийг баримжаа болгосон Испанийн далайч Х.Колумб XVI зуунд Монголын эзэнт гүрэн байсан нутаг орныг зорих аян замдаа төөрч будилан бүр эсрэг зүгт далийхдаа Америк тивийг нээсэн. Австрали тивийг XVII зууны үеэс л мэдэх болжээ.

Монголчууд ёс суртахууны эерэг энергизрээ дэлхий дахиныг засан тохинуулсныг Жувейн “Чингис хаан ганцаархнаа, бараг зэр зэвсэггүй гэмээр цөөн цэрэгтэй байж, ... дорноос өрнө хязгаар хүртэлх эрх мэдэлтнийг бараг тулалдалгүйгээр эрхэндээ оруулж чадсан” (Жувейни, 2006, хууд. 18), алдарт Марко Поло “Чингис хааны засаглал шулуун шударга болохыг үзсэн бусад орны хүн ард түүнтэй өөрсдөө ирж нийлэн нэгдсээр байв. Нэг мэдэхэд түүнийг дагалдагсад, дэмжин талархагсад газар дэлхийг хучин бүрхсэн үй түмэн болсон” (Лейтхим, 2012, хууд. 147) гэж бичиж үлдээсэн байна. Үүнийг Уйгар⁵, Хар Кидан /Хятан/⁶, Карлук /Харлаг/⁷, Солонгос зэрэг олон улс гүрэн Монголд дагаар орж, Их Монгол Улс бүрэлдэж буй болсон явдал нотолно.

XIII зуун буюу Монголын амар амгалангийн (Pax Mongolica) эрин үед урьд өмнө хаагдсан торгоны замыг дахин нээж, Евроазийн их худалдааны бүсийг цэцэглүүлэн хөгжүүлж, улс хооронд соёлын харилцаа тогтоож, Газрын дундад тэнгисийн Венеци, Генуягаас Их Монгол Улсын дундуур дайрч, Хятад хүрэх замын нутаг дэвсгэрийн аюулгүй, найдвартай байдлыг хангаж, монголчууд очсон улс орныг нутгийнх нь голч шударга хүмүүсээр удирдуулснаар Дорно, Өрнө хоёрыг нягт холбож өгчээ. Түүний үр шимийг Европчууд, Төв Азийн лалынхан, еврейчүүд, хятадууд, Азийн бусад улс түмэн хүртжээ.

Энэ тухайгаа Чингис хаан “Гүр (нийт гэсэн эртний үг С.Н. тодотгов) улсыг шударга болгож, гагц жолоонд оруулж чадсан” (Монголын нууц товчооны 224 дүгээр зүйл.) хэмээн айлдсан юм. Чингис хааны “Миний бие умар зүгийн их хээр талд аж төрөн сууж, чигч шударгыг эрхэмлэн тогтоогоод, бүрэлгэн сүйтгэхийг хориглон зогсоож, өмсөх хувцас, идэх хоолоо адуучин, үхэрчинтэйгээ хуваалцан, ард иргэдийг хүүхэдтэйгээ адил үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүүгээ мэт хүндэлж, эе эвийг сахиулж, энэрэл хишгээ түгээмүй” (Чанчунь, 2010, хууд. 18) хэмээсэн айлтгал та бидэнд нэгийг өөрийн эрхгүй бодогдуулна.

⁴ Венецийн Марко Поло Хубилай хааны дэргэд 20 жил алба хаажээ.

⁵ Эдүгээгийн БНХАУ-ын Шинжаан-Уйгарын Өөртөө Засах орон хавьд төвлөрч байжээ.

⁶ Эдүгээгийн Шинжаан болон түүнээс баруун тийших нутаг дэвсгэрийг эзэмшиж байжээ.

⁷ Эдүгээгийн Казахстаны зүүн өмнөд хавь оршин тогтнож байжээ.

Монголчууд эрт дээр цагаас төрийг биологийн бус амьд организмтай зүйрлүүлэн жишиж үзэх болжээ. Төр бол нэг ёсондоо улс орныг удирдах эрх мэдэл юм. Их эзэн Чингис хааны өмнө дурдсан айлтгалд шударга ёс (чигч шударгыг эрхэмлэн тогтоосон), нинж өгөөмөр сэтгэл (өмсөх хувцас, идэх хоолоо адуучин, үхэрчинтэйгээ хуваалцан, ард иргэдийг хүүхэдтэйгээ адил үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүүгээ мэт хүндэлсэн), эв нэгдэл (эв эеийг сахиулсан), энэрэхүй (энэрэл хишгээ түгээсэн) зэрэг ёс суртахууны эрхэм нандин өгөгдөл багтсан байгаа болно. Энд л монголчууд төрийн сүлдэндээ залбирч ирсний учир оршжээ. Ийнхүү XIII зууны үед монголчууд дэлхий дахинд шударга ёс, энхийг тогтоож явсан хүчирхэг үндэстэн байсны нууц нь тэдний ёс суртахуунд хадгалагдаж байжээ.

Хүчирхэг монгол үндэстэн сулран доройтсоны шалтгаан

Хүмүүн ой санамждаа буй ёс суртахууны эерэг энергийн өгөгдлөө үл ойшоож, түүнийгээ орой дээрээ залахаа боливол чухам юунд хүргэдгийг суут мэргэд судлан шинжилж иржээ. Тухайлбал: суут Ш.Монтескьо "... ахмадууд нэр хүндгүй болно. Хэрэв ахмадаа хүндлэхгүй бол эцгээ ч тоохгүй. Хүн бүр л дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэнэ. Эхнэр нь эр нөхрөө хүндэтгэхээ болино. Эхнэр, хүүхдүүд хэний ч үгэнд орохоо болино. Ёс суртахууныг сахих, эмх журмыг эрхэмлэхүй эрлэгт тонилж, буянт үйл хулжин одно" (Монтескьо, 2009, хууд. 97) гэж дүгнэн бичиж байжээ.

Хүчирхэг монгол үндэстэн сулран доройтсоны гол шалтгаан нь зарим монголчуудын ёс суртахууны өгөгдлийн найрсаг эелдэг, зочломтгой нь бүдүүлэг, хүйтэн цэвдэг; шударга нь шударга бус; эрэмгий зориг нь аймхай хулчгар, дайчин бус; ичгүүр нь эрээ цээргүй; үүрэг нь гагцхүү эрх; хариуцлага нь хайнга, хэнэггүй, цалгар назгай; нинжин сэтгэл нь харгис хэрцгий, балмад; жудаг нь хүний мөсгүй; үнэн нь худал хуурмаг; итгэл нь заль мэх, хулхидалт; тэсвэр тэвчээр нь хүлээцгүй, сэтгэлийн хөдлөлөө барьж чаддаггүй; эв нэгдэл нь талцал хагарал; хамтач нь хувиа хичээх; тусархаг нь харамч; атгаг бус нь өш хонзон, үзэн ядалт, дайсагналцал; эс урвалт нь урван тэрслэлт болон хувирсантай холбоотой юм.

Ёс суртахуунаа уландаа гишгэж, эрх мэдэл хөөцөлдөн булаацалдаж, талцаж, бие биеэ үзэн ядаж, дайсагналцсаны гор нь хэмжээлшгүй их болохыг үндэсний эв нэгдлээ бусниулсан Их Монгол Улс жижгэрэн жижгэрсээр Манж Чин Улсад дагаар орсон харамсалтай түүх маргашгүй нотлон харуулна.

Манж Чин Улсад дагаар орсноор юуны өмнө тэр үеийн Монголын элит хэсэг Чингис хааны үеийн "Элдэв цол, гуншин хэрэглэх нь тун бага тул тийм цол хэргэмдээ эрдэн ихэрхэх бардамнах явдал гардаггүй сайхан заншилтай байлаа. Хаан ширээнд суусан нэгнийгээ хаан гэж өргөмжлөхөөс бус элдэв цол хэргэм үл хэрэглэнэ. Хааны хөвүүд, дүү нарыг ч албан бичиг сэлтэд зөвхөн өгсөн нэрээр нь л нэрлэнэ. Ихэс дээдэс, харьяат ард энэ заншлыг дагаж мөрдөнө" (Жувейни, Дэлхийг байлдан дагууулагчийн түүх. Мизра Мухаммед Казванийн эмхэтгэсэн номыг перс

хэлнээс англи хэлээр орчуулсан Бойль Ж.Э., Орос хэлнээс орчуулсан Бадамням М., 2006, хууд. 21) гэсэн журамлалаас тойрон гарч, эрх мэдэл, цол хэргэм, цалин пүнлүү, бэлэг сэлтэд бие биеэсээ өрсөн улайрах болов.

Зөвлөлтийн нөлөөнд орсон жилүүдэд уламжлалт ёс суртахуунаа феодализмын хоцрогдолд, гайхамшигт өвөг дээдсийнхээ энгүй их сэцэн билэг, сэтгэлгээний тэнхээ, цар хүрээг харанхуй бүдүүлэгт тооцож, ЗХУ-ын юм болгоныг үг сүтгүй даган дуурайв. ЗХУ-д боловсрол эзэмшсэн монгол хүнээ нэгд эрэмбэлж, эх орондоо боловсрол эзэмшсэн бол хоёр, гуравт эрэмбэлэгдэж, ёс суртахуунд ач холбогдол өгөхөө болив. Наад зах нь монголчуудын - Амар байна уу? хэмээн эхэлдэг найрсаг мэндлэх ёс орос хэлний “ – Здравствуйте?” буюу – Сайн уу?, Юу байна? гэх зэрэг чихэнд чимэггүй үгээр солигдож өөрчлөгдөв. Та, өөрөө хэмээсэн хүндэтгэлийн монгол сайхан үгийн оронд орос хэлний “Ты” буюу “Чи (чамаар)” хэмээх үгийг хэрэглэх болов. Монгол хүний ёс суртахууны эс шунахуйн өгөгдлийг “нэрэлхүү”, ичимтгий өгөгдлийг “бүрэг” гэх мэтээр гоочлон гутаах болов. Монгол ёс суртахуун социалист тогтолцооны жилүүдэд иймэрхүү л болж хувирсан юм.

Ардчиллын жилүүдэд монголчуудын ёс суртахуун социализмын үеийнхээс огт дээрдсэнгүй. Энэ жилүүдэд ёс суртахууныг хүчил мэт өөртөө уусгагч гагцхүү хэрэглээг шүтэх ёсонд Монголын нийгэм бүхэлдээ шилжив. Хөгжил хэмээн үзээд байгаа эдүгээгийн өндөр байшин, тансаг хаус, цардмал зам, машин тэрэг, гар утас, интернэт зэрэг үй олон хэрэглээ монголчуудад аз жаргал авчирсангүй. Өнөөдөр Монгол Улсад ёс суртахуун ба хууль хоёрыг зааглан тусгаарлаж, хуулийг хууль тогтоогчдын дур зоргын хэрэг болгон мөнгө, ашиг ба элдэв янзын хэрээс хэтэрсэн хэрэглээ тансаглалыг аминчлан чухалчилж, монголчууд ёс суртахуунаараа аж төрөхөөс түдгэлзэх болсноос хойш элдэв янзын олон хүндрэл бэрхшээлтэй байнга нүүр тулах болжээ. Шуудхан хэлэхэд эдүгээ шударга үнэнч нь гэнэн тэнэг, харин зальхай, шунахай нь ухаантайд тооцогдох болов.

Хөгжил дэвшлийн төлөө 1990 оноос хойш хэчнээн олон хууль, үзэл баримтлал, хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлсэн боловч хүссэн үр дүнд хүрсэнгүй. Хамгийн сүүлд УИХ-аас баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод ёс суртахууны гүйцэтгэх үүргийн тухай ямар нэгэн тодорхой асуудлыг хөндөж тавьсангүй, “Ирэх гучин жилд монгол хүн бүр эрүүл аж төрж, аз жаргалтайгаар урт наслах, насан туршдаа чанартай, тэгш хүртээмжтэй боловсрол эзэмшиж, хангалуун амьдрал буй болгох гол зорилго оршино” (“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2019, хууд. 108) гэсэн зорилго тавьжээ. Ард иргэдээ ёс суртахуунлаг болгох үүргийг төрийн үндсэн чиг үүрэг болгоогүй, энэ нэн чухал үүргээс төр өөрийгөө чөлөөлчихсөн, ёс суртахууны тухай Үндсэн хуульдаа тусгаагүй, ёс суртахууны үлгэр дуурайлыг төр өөрөө үзүүлж чадахгүй байгаа нөхцөлд хөгжлийн ямар ч бодлого хэрэгжих боломжгүй гэдгийг ард өнгөрсөн жилүүд нотлон баттай харуулав. Одоо яах вэ? Ямар гаргалгаа байна вэ?

Гагцхүү ёс суртахуун л бүхнийг шийдвэрлэнэ

Ёс суртахуун XIII зууны үеийн байр сууриндаа эргэн очиж, хүн болгон ёс суртахууныг амь биеийнхээ салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгож, айл өрхийн гал голомт лугаа адил тахиж, үр хүүхдээ ёс суртахуунлаг болгон төлөвшүүлж, суртахууныг үндэсний язгуур үзэл санаа болгож чадсан цагт л Монголын ард түмэнд нүүр тулгарсан бэрхшээл, хүндрэл нааштайгаар шийдвэрлэгдэнэ. Үүний тулд дараах асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай болсон. Үүнд:

- *Гэр бүл*: Монгол хүмүүн ёс суртахуунлаг байх эсэхийг шийдвэрлэгч анхдагч орчин гагцхүү гэр бүл мөн. Эцэг ба эх нь үр хүүхдийнхээ удамшил болон орчинг нэгэн зэрэг бүрдүүлдэг. “Буруу өсгөсөн хүүхэд бухын хүзүүнээс хатуу” хэмээсэн монгол ардын зүйр үг нэг ёсны бичигдээгүй хууль жам ёсны хууль юм.
- *Боловсрол*: Энэ нь гайхамшигт өвөг дээдсийнхээ агуу их ухаанаас ямагт суралцаж, түүнд суурилан амьдралынхаа утга учрыг мэдэж, хувь тавилангийнхаа зүг чиг, эрч хүч, эрдэм мэдлэгийг олж авах явдал мөн. Монгол үндэстний аж төрөх ёсны нэгдмэл орчин, ертөнцийг үзэх үзэл төрөлх хэлэнд нь огшсон болохыг умартах ёсгүй. Эрдэм мэдлэг бол суут сэтгэгчдийн сургаал сургамж юм. Багш нар бол ёс суртахуунаараа шавь нараа үлгэрлэн дагуулагч, халамжлан хүмүүжүүлэгчид билээ.
- *Соён гэгээрэхүй*: Ард түмнээ соён гэгээрүүлэх олон төрлийн ажил үйлс нь ёс суртахуунлаг хүмүүнийг бүрдүүлэхэд онцгой ач холбогдолтой. Олон жилийн туршид орхигдсон энэхүү нэн чухал ажил үйлсийг дахин сэргээх цаг нэгэнт болжээ.
- *Шашин*: Хүмүүн гээч өөрийн хүч чадлаас хол давсан өвчин, зовлон, зүдгүүр, сэтгэл санааны гүн хямралтай нүүр тулахдаа өөрийн эрхгүй өөрөөсөө илүү хүч чадалтай, бүхнийг чадагч хүчин зүйлийг эрж хайдаг нь чухамдаа шашин буюу бурхан болой. Тэдгээр нь хүмүүний зүрхэн дотор эргэн хургаж, элдэв муу хүлээсийг нь тайлж, сэтгэлийг нь ариусгасан нөхцөлд тэрхүү ариуссан зам мөрөөс нь буцааж гаргах хүч энэ хорвоод байхгүй.
- *Хууль*: Энэ нь ёс суртахууныг ариглан хамгаалагч мөн. Хэрэв ёс суртахууны эерэг өгөгдлийг ноцтой гажуудуулсан бол тухайн хүмүүнд хуулиар тогтоосон хариуцлага хүлээлгэх нь зүйн хэрэг. Ингэхээр хуулийн амин сүнс нь ёс суртахуун болж байдаг. Зөвхөн хуулийн хуурай үг үсэгт бүрэн эрхшээгдэж, ёс суртахууныг үл хайхрах аваас улс орон, ард түмэн огт дээрдэхгүй.
- *Эдийн засаг*: Монголд баяжсан хүн улам л их баяжихаар цөхрөлтгүй улайрдаг нь жам ёсны үзэгдэл болжээ. Учир нь төр засаг болон ер нь юуг ч мөнгөөр худалдаж авч болно гэсэн үзэлд хязгаар гэж ер байхгүй. Энэ учраас эрүүл мэнд, боловсрол, амин зуулга (гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн) зэрэг амин чухал салбарыг зөвхөн ашиг олох талбар болгохоос зайлсхийж, зах зээлээс хамгаалах явдал Монголын нийгмийг ёс суртахуунжуулахад нэн чухал ач холбогдолтой.

- *Улс төр*: Мөнгө хийх, албан тушаал дэвших арга хэмээн ойлгосон, сэтгэлгээ нь шийдвэрлэх асуудалдаа багадсан хүмүүсийг өөртөө татсан намууд эх орныхоо хүндрэл бэрхшээл дээр ашиг хийж буй бизнес бүлэглэл болж хувирсныг нэн даруй засамжлах цаг нэгэнт болжээ. Улс орон, ард түмнийхээ сайн сайхны төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр чин шударгаар хүчин зүтгэж, ачааны хүндийг нуруундаа нэр төртэй үүрэх чадвартай хүмүүсийг улс төрд гаргах арга замыг нэн яаралтай сүвэгчлэн олох шаардлагатай байна.
- *Утга зохиол, урлаг*: Эдгээр нь хүмүүний ёс суртахуунд хүчтэй нөлөөлөх чадамжийг агуулдаг. Ёс суртахууны эерэг энергийн тухай утга зохиол, урлагийн даацтай бүтээл туурвиж, олон нийтийн хүртээл болгох нь Монголын нийгмийг ёс суртахуунжуулахад асар их ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэж байна.
- *Хэвлэл мэдээллийн хэрэгсэл*: Эдгээр нь ард түмний зүрх сэтгэлийг ямагт “хөндөж байдаг” учраас нийгмийг ёс суртахуунжуулахад тэргүүн зэрэгт тавигдах учиртай.

Төгсгөл

Монгол хүн бүр өдөр тутмынхаа амьдралд ёс суртахуунлаг байж чадвал Монгол Улс монголоороо үүрд мөнхөд оршиж, Монголын ард түмэн төрөлх эх орондоо аз жаргалтай, сэтгэл тэнүүн аж төрцгөөх болно. Монгол ёс суртахуунд улс үндэстний маань оршин буй заяамал нөхцөлтэй шүтэн барилдсан аж төрөх ёсны язгуур хэв маяг, өвөг дээдсийн маань агуу их ухаан, түүнээс үүдэлтэй уламжлал, сургамж, соёл, сэтгэлгээний хэв маяг, хөгжлийн загвар хадгалагдаж байгаа гэдгийг сайтар ухаарах цаг үетэй монголчууд бид золгож байна. Энэ бол “Айлаас эрэхээр авдраа уудал” гэсэн монголчуудын бичмэл бус хууль юм.

Fundamental views of the Mongolian people

Narangerel Sodov

Academician of the Mongolian Academy of Sciences, Doctor of Science (Sc.D), narangerel@iss.gov.mn
Professor Emeritus of the National University of Mongolia

Abstract

This article seeks to explain why the Mongolian nation was the most morally virtuous and powerful nation in the world during the 13th century, why it subsequently declined and fell into foreign subjugation, and why, despite having regained national independence, it has yet to achieve a full revival.

Today's Mongolia, which preserves the hearth of Chinggis Khaan, has considerably lost its traditional moral compass. As a result, despite possessing a rich historical and cultural heritage, a vast territory, the world's sole remaining pastoral nomadic civilization, a talented populace, and abundant natural resources, the country has found itself with no choice but to be swept along by external currents to its own disadvantage. Under these circumstances, the country has focused solely on short-term concerns. Therefore, this article earnestly endeavors to discuss the vital importance for Mongolians of reviving their cherished moral heritage.

Keywords: Independence; moral value; unity; belief; nomadic civilization; social values

Received: June 18, 2026 | Accepted: June 29, 2026 | Published online: July 07, 2026



© The Author(s) 2026

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.